

МОНГОЛ УЛСЫН “ЗӨӨЛӨН ХҮЧ”- НИЙ БОДЛОГО

D.Urantsetseg@must.edu.mn



ТУЛГУУР ОЙЛГОЛТ

ЗӨӨЛӨН
ХҮЧ

ХАТУУ
ХҮЧ

ҮНЭТ
ЗҮЙЛ


ПРАГ
МАТИК

ДЭЛХИЙН
МОНГОЛЧУУД
ХӨТӨЛБӨР

Зөөлөн хүч (англи. soft power)

Гол төлөв гадаад бодлогод хэрэглэдэг томъёо бөгөөд бодлого хэрэгжүүлэх нэгэн хэлбэр юм. Бусдад хүчээр бус өөрийнх нь сонирхол, сайн дурынх нь үндсэн дээр нь тулгуурлан хүсэл сонирхолоо гүйцэлдүүлж түүнд нөлөөлөхийг хэлнэ.

ЗӨӨЛӨН, ХАТУУ ХҮЧНИЙ ЯЛГАА



«Зөөлөн хүч» (англи. soft power) ойлголтыг анх Америкийн улс төр судлаач, Харвардын их сургуулийн профессор Жозеф Най 1980-аад оны сүүлээр "Нэг улс бусад улс орнуудаас хүсч буй зүйлээ хийхийг хүчээр тушаахаас ялгаатай нь хамтран ажиллаж эерэгээр ойлгуулахыг зөөлөн хүч гэж нэрлэж болно" гэж тодорхойлжээ.

SOFT POWER

THE MEANS
TO SUCCESS
IN WORLD
POLITICS

ЗӨӨЛӨН ХҮЧ-ДИПЛОМАТ БОДЛОГО

Жозеф Най

"Зөөлөн хүч нь гадны улс оронтой харилцахдаа бусдын сонирхол татахуйц соёл, урлаг, үнэт зүйл, гадаад бодлого, санхүүгийн боломжоо ашиглан хүссэн үр дүнд хүчээр бус хүрэхийг хэлнэ"

"Зөөлөн хүч гэдэг нь тодорхой нэг чиглэлээр өөрийн зорилгодоо хүрэхийн тулд бусад оронтой хамтран ажиллаж эерэг, нааштай ойлголтыг бий болгож нөлөөлөх чадвар юм"

Түүхэн байдал:

Өөрийн эрх мэдлээ тогтоохын тулд "зөөлөн хүч"-ийг ашиглах санаа нь МЭӨ 7-р зуунд амьдарч байсан эртний хятадын гүн ухаантан Лао Зы-гаас гаралтай гэж судлаачид үздэг байна. Тэрээр "Дэлхий дээр уснаас илүү зөөлөн биет байхгүй, гэхдээ ус нь хамгийн хатуу биетийг ч устгаж чадна" гэсэн нь үүнийг баталж байдаг.

ЗӨӨЛӨН ХҮЧНИЙ ТӨРЛҮҮД



**Бизнес,
инноваци**



Соёл



**Улс
төрийн
үнэт зүйл**



**Гадаад
бодлого**



Боловсрол

Үйл ажиллагаа-6.2

Сурах бичиг-188 хуудас


**Мэдээллийг уншаад асуултад
хариулаарай**

“ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД” ХӨТӨЛБӨР


Өнөөдөр дэлхийн өнцөг буланд бүрд 175 гаруй мянган монгол иргэд ажиллаж, амьдарч, жилд дунджаар 500 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний мөнгөн шилжүүлгийг эх орондоо хийдэг гэсэн судалгаа байна. Монгол иргэд дэлхийн 87 улсад ажиллаж, амьдарч байна.




БНСУ-д
37000 иргэн



АНУ-д
30000 иргэн



Швед улсад
10 538,иргэн



Францад
7 000 иргэн



Германд
6420,иргэн

БАТАТГАЛ

ПРАГМАТИК

Олон улсын харилцаанд социалист эсвэл капиталист гэх мэт үзэл санаа бус харин бодит ашгийг эрхэмлэх прагматик байр суурь давамгайлах болсон. Энэхүү прагматик байр суурийг 19 дүгээр зууны сүүлээр Их Британийн Ерөнхий сайд асан Генри Пальмерапон “Бидэнд мөнхийн холбоотон гэж байхгүйтэй адил байнгын дайсан гэж үгүй” гэж тодорхойлсон

ХАТУУ -ЗӨӨЛӨН ХҮЧ

Хатуу хүч- Цэрэг,зэвсгийн хүчээр эдийн засгийг шийдэхийг хэлнэ .

Зөөлөн хүч-Тухайн улсын шинжлэх ухаан, техник, спортын ялалт амжилтыг бахархах явдал. Зөөлөн хүч хатуугийн эсрэг бус харин олон улсын тавцанд хатуу хүчний үйлчлэлийг илүү үр дүнтэй болгодог, хатуу хүч нь зөөлөн хүчнийхээ эх үүсвэр болдог.Хатуугийн эсрэг бус харин үйлчлэлийг нь нэмэгдүүлдэг төдийгүй эдийн засагт илүү ашигтай.

ҮНЭТ ЗҮЙЛ

Зөөлөн хүчийг үнэт зүйлсээрээ илүү байр суурьтай улс ашигладаг. Жозеф Най энэ талаар бичихдээ “Бусад хүн таны биширдэг, шүтдэг зүйлсийг бахдан дээдэлж дагадаг, хүсч буй зүйлийг чинь адилхан хүсдэг болгож чадвал өөрийн хүссэн зүгт тэднийг чиглүүлэхийн тулд сүрдүүлж эсвэл аргадах шаардлагагүй болно” гэжээ.

ГЭРИЙН ДААЛГАВАР

**Үйл ажиллагаа 6.13
Асуултад хариулаарай**